



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

Гадаадын мэргэжилтэнд Монгол Улсад
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн гадаадын 3 эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Тушаал гарсантай холбогдуулан хавсралтад дурьдсан гадаадын мэргэжилтэнд зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгох ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД




Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081401

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 0.9 дугаар сарын 4 өдрийн
354 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Мэргэжлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Үйл ажиллагаа эрхлэх хугацаа
1.	Санчес Карпио Франк Эдуардо	Эквадор	"Сонго" эмнэлэг	ГЭ0001441	Дүрс оношилгоо	Эмчлэх	1 жил
2.	Жон Сү Гён	БНСУ	АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг	ГЭ0001442	Эмгэгтэйчүүдийн эмч	Эмчлэх	1 жил
3	Жон Мүн Уг	БНСУ	Грийн Хоум эмнэлэг	ГС0000296	Сувилагч	Сувилах	1 жил